

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 3-р сарын 9

Дугаар 15

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнийг түр орлох этгээд томилох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5, 77.6 дахь заалт Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.5, 9.2.9 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.1, 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Чинзоригийн өөрийн хүсэлтийг харгалзан үзэж 2021 оны 3-р сарын 9-ний өдрөөр тасалбар болгон ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлсүгэй.
2. Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2021 оны 3-р сарын 9-ний өдрийн 01 тоот тогтоол болон Цалин урамшууллын хорооны 2021 оны 3-р сарын 9-ний өдрийн 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болох хүртэл компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Чинзоригийг түр орлох этгээдээр Монгол Улсын иргэн Бямбажав овогтой Энх-Амгаланг томилсугай.
3. Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.6-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол улсын иргэн Бямбажав овогтой Энх-Амгалан нь Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүний эрхийг 2021 оны 3-р сарын 9-ний өдрөөс эхлэн ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болох хүртэл хугацаанд эдлэхийг дурдсугай.
4. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлохоор томилогдсон Монгол Улсын иргэн Бямбажав овогтой Энх-Амгаланд Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох журмуудыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.
5. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох этгээд томилогдсон тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч. Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ